



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

**2026 оныг “Ёс зүй, сахилга, хариуцлага,
хяналт, бүтээмжийг дээшлүүлэх” жил
болгон зарлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.14.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2026 оныг “Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт, бүтээмжийг дээшлүүлэх” жил болгон зарласугай.

2.“Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт, бүтээмжийг дээшлүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сард батлуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг улирал бүр тайлагнаж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Даваахүү)-т, Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар (Ц.Ганцэцэг)-т, Хяналт шалгалтын газар (С.Лхагвадорж)-т, Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар (Б.Батсүх)-т, Ёс зүйн дэд хороо (Ц.Ганцэцэг)-нд, үр дүнг олон нийтэд мэдээлэн сурталчлахыг Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар (Б.Батсүх)-т, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нарт, орон нутгийн онцлогт нийцүүлэн төлөвлөгөө батлан, хэрэгжүүлэн ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.“Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт, бүтээмжийг дээшлүүлэх” жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2026 оны 07 дугаар сарын 15, 2026 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус хяналт-үнэлгээ хийж, үр дүнг танилцуулахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т даалгасугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Даваахүү)-т даалгасугай.

ДАРГА

Б.БАТЖАРГАЛ



1526810003